

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ХЭЛТЭС**

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН
ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ
ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТАЛААР**

2020 он

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ

Оршил

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталж, баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 4 бүлэг, 19 зүйлтэй.

Энэхүү хууль нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үйлчлэх бөгөөд энэ хугацааг Монгол Улсын Их Хурал зургаа хүртэл сараар нэг удаа сунгаж болно.

Хуулийн үзэл баримлал

Коронавирусын төрөл нь амьсгалын замын эд эсийг гэмтээж, уушгины хатгалгаа үүсгэдэг, урьд өмнө бүртгэгдэж байгаагүй, 4 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар дэлхийн 213 улс оронд 2 сая хүний өвчлөл бүртгэгдэж, нас баралтын тоо 136908-д хүрсэн бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас коронавирусын халдварын тархалтыг цар тахал гэж зарласан.

Монгол Улсад 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс хойш тусгаарлан ажиглах байруудад 1669 хүнийг авч, 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар гадаад улс орноос 31 тохиолдол зөөвөрлөгдөн орж ирсэн.

Аливаа халдварт өвчний тархалттай үед төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдүүлэх зайлшгүй шаардлагатай хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм, гадаад улс орнуудаас ирэх зорчигч, хил нэвтрэх, дамжин өнгөрөх бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн баримт бичгийн хяналт, бүртгэл, дотоод болон хил дээрх ариутгал, халдваргүйжүүлэлт, тархалтын хариу арга хэмжээний талаар хуулийн зохицуулалт хангалтгүй байгаа ба шаардлагатай арга хэмжээ авах, холбогдох журам, зааврыг батлах эрх төрийн байгууллагад хуулиар олгогдоогүй байгаа нь коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед нийгмийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэмцэхэд хүндрэл үүсгэх үндсэн шалтгаан болж байгаа тул цар тахлын үед, Засгийн газраас өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд тусм халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хуулийн тодорхой зохицуулалт хийх шаардлага урган гарсан гэж хууль санаачлагч нар үзсэн.

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед цагдаагийн байгууллага,

алба хаагчийн ажиллах баталгааг сайжруулах, цахим орчин дахь олон нийтийг төөрөгдүүлэх мэдээлэлд хяналт тавих, төр, иргэн, хуулийн этгээдэд хүлээх үүрэг, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын чангатгах чиглэлээр дараах зохицуулалт орсон болно. Үүнд:

1-рт, цар тахлын үед баримтлах зарчмыг хуульчлав. Тухайлбал, хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор бусад хуульд зааснаас өөр журам тогтоох, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг авч ажиллах талаар;

2-рт, Улсын Их Хурлын бүрэн эрх, Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Засгийн газар, Улсын онцгой комисс, Төрийн бусад байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааны талаар, Тухайлбал, Улсын Их Хурал хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал түр хороогоор дамжуулан сар бүр биелэлтийг авч хэлэлцэх, Засгийн газар шаардлагатай дэглэм, журам, зааврыг батлах, батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, түр хамгаалах байранд шаардлагатай хөрөнгө оруулалт болон 2 цагаар ажиллуулах утасны санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, Комисс нөөц хуваарилах, бүрдүүлэх, шүүгч, прокурорыг 24 цагаар ажиллуулах журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор баталж, зохион байгуулах, цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим хуудсанд зохицуулалт хийх журмыг цагдаагийн төв байгууллага, харилцаа холбооны зохицуулах хороо хамтран батлахаар тусгав;

3-рт, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг тус тус хуульчлав. Тухайлбал, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалтын дэглэм, заавар, журам, шаардлага, сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмжийг сахин биелүүлэх, худал мэдээлэл түгээхгүй байх, цар тахлын эсрэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах талаар тусгасан. Харин хэвлэл мэдээллийн байгууллага нь цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Комисс болон эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээллийг үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлэх ба цар тахлын талаар мэдээллийг үнэн бодит, баталгаатай эх сурвалжаас авч байхаар хуульчилав;

4-рт, Эд хөрөнгийн дайчилгаа, түүнд нөхөн олговор олгох асуудлыг тодорхойлон хуульчилсан;

5-рт, төрөөс эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдад моргейжийн нэн хөнгөлөлттэй зээл олгох замаар нийгмийн баталгааг хангах тусгай төлөвлөгөөг баталж, санхүүжүүлэх, сонгууль зохион байгуулагдах хугацаанд цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч, холбогдох зардлыг шийдвэрлэхээр, эрүүлжүүлэх, баривчлах байранд байгаа иргэний эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эм,

эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах асуудлыг тус тус хуульчилсан;

6-рт, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөн олговор, урамшуулал олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэхээр тусгасан;

7-рт, хуульд төрийн албан хаагчдад түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны зээл гаргахаар нэмж тусгасан;

8-рт, цагдаагийн байгууллагаас боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн саналыг хэлэлцэн баталлаа. Батлагдсан хуулиар гамшгийн үед хорио цээр, хөдөлгөөний дэглэм зөрчсөн бол, зохиомол үнийн хөөрөгдөл, хомсдол бий болгосон бол эрүүгийн хариуцлага хүлээхээр, худал мэдээлэл түгээх, хорио цээрийн дэглэм зөрчсөн, хэвлэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй, саад учруулсан бол шийтгэл оногдуулахаар тусгаж, хариуцлагыг чангатгасан байна.

Иймд “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-д цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой хэрэгжүүлэх зүйл, заалтаас түүвэрлэн энэхүү мэдээллийг боловсрууллаа.

Хуулийн бүтэц

№	Бүлэг	Зохицуулсан харилцаа
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>2 дугаар зүйл.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль тогтоомж</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>5 дугаар зүйл.Үйл ажиллагаанд баримтлах зарчим</p>
2	Хоёрдугаар бүлэг Төрийн болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ	<p>6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>7 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>8 дугаар зүйл.Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>9 дүгээр зүйл.Төрийн бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>10 дугаар зүйл.Төв банк болон арилжааны</p>

		банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ 11 дүгээр зүйл. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, арга хэмжээнд тавих шаардлага
3	Гуравдугаар бүлэг Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг	12 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг 13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг 14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг
4	Дөрөвдүгээр бүлэг Бусад зүйл	15 дугаар зүйл. Хандив 16 дугаар зүйл. Эд хөрөнгийн дайчилгаа 17 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 18 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хугацаа 19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Зорилт /1 дүгээр зүйл/

Энэ хуулийн зорилт нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал /цаашид “цар тахал” гэх/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн үйлчлэх хүрээ /3 дугаар зүйл/

1/Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулах бөгөөд энэ хуульд зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

2/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиас бусад хуулийн дагуу олон нийтийг биечлэн хамруулах арга хэмжээг зохион байгуулах, албан тушаалтныг сонгон шалгаруулахаар хуульчилсан зохицуулалтыг энэ хуулийн үйлчлэл зогссон өдрөөс эхлэн тухайн хуульд заасан хугацааг баримтлан хэрэгжүүлнэ.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт /4 дүгээр зүйл/

№	Нэр томъёо	Тодорхойлолт
1	тохиолдол	тухайн өвчний батлагдсан болон сэжигтэй, магадлалтай тохиолдол бүрийг
2	халдвар	халдварт өвчин үүсгэгч хүн, амьтны биед нэвтрэн орж, өсөж үржихийг

3	хөл хорио	тодорхой хугацаанд хүн ам, газар нутгийг хамарч халдварт өвчин тархахаас сэргийлэх, халдварыг анх гарсан голомтод нь барих, хяналтад авахад чиглэсэн арга хэмжээг
4	тусгаарлах	халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүн, халдвараар бохирлогдсон сэжигтэй гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмжийг тусгаарлахыг
5	ажиглах	халдвар дамжих аюулыг тодорхойлох зорилгоор тодорхой хугацааны туршид хүний эрүүл мэндийн байдлыг хянах үйл ажиллагааг
6	халдварлагдсан	хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулах халдвар тээгч хүн болон халдвараар нас барсан хүний цогцос, халдвар үүсгэгчээр бохирдсон эд хэрэглэл, гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмжийг
7	халдваргүйжүүлэлт	хүний болон амьтны биеийн гадаргуу дээр, эсхүл гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмжийн дотор болон гадна хэсэгт байгаа халдвар үүсгэгчийг физик болон химийн аргаар устгах, эсхүл тоог цөөрүүлэх арга хэмжээ авахыг
8	халдварын сэжигтэй	хүн амын эрүүл мэндэд аюул занал учруулж болох эрсдэлд өртсөн буюу өртсөн байх магадлалтай, өвчин тараах эх үүсвэр байж болзошгүй хүн, гар тээш, ачаа, чингэлэг, тээврийн хэрэгсэл, бараа, шуудангийн илгээмжийг

Үйл ажиллагаанд баримтлах зарчим /5 дугаар зүйл/

1/хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, эмнэлгийн үйлчилгээ тэгш, хүртээмжтэй байх.

2/шуурхай, ил тод, хариуцлагатай байх.

3/олон улсын эрүүл мэндийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх.

4/нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор бусад хуульд зааснаас өөр журам тогтоох, хүний зарим эрх, эрх чөлөөг хязгаарлах.

5/ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх.

6/байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг авах.

Төрийн болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1	<p>Монгол Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p><i>/6 дугаар зүйл/</i></p>	<p>1/Монгол Улсын Их Хурал цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>1.1.цар тахлын үед шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг дараалал харгалзахгүйгээр хэлэлцэн шийдвэрлэх;</p> <p>1.2.цар тахлын үед шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу шуурхай хянан хэлэлцэх;</p> <p>1.3.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд тогтмол хяналт тавих.</p> <p>2/Монгол Улсын Их Хурал энэ хуулийн биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын бүх Байнгын хорооны болон Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулна.</p> <p>3/Түр хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>3.1.энэ хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэх;</p> <p>3.2.бусад Байнгын хороогоор энэ хуулийн биелэлтийг хэлэлцүүлэх санал гаргах.</p>
2	<p>Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p><i>/7 дугаар зүйл/</i></p>	<p>1/Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>1.1.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг батлах;</p> <p>1.2.цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, хямралын эсрэг холбогдох санг арвижуулах зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;</p>

1.3.эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүний хүүгийн татаасаар Төв банканд дэмжлэг үзүүлэх;

1.4.цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх;

1.5.цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх;

1.6.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, уг үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагыг татан оролцуулах журмыг Улсын онцгой комиссын санал болгосноор батлах;

1.7.нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд болон зарим нутаг дэвсгэрийн хэмжээнд хязгаарлах;

1.8.өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх;

1.9.бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах;

1.10.шашны байгууллагын шашин номын хурал, цуглааныг олон нийтийг биечлэн хамруулан зохион байгуулахыг тодорхой хугацаагаар зогсоох;

1.11.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах;

1.12.цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах;

1.13.төрөлжсөн асрамжийн газар, түүнчлэн эрүүлжүүлэх, баривчлах, цагдан хорих байр, хорих

ангид байгаа болон бусад хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;

1.14.эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгсэл, хүнсний болон бусад шаардлагатай барааг улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг шийдвэрлэх;

1.15.цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой зардлыг шийдвэрлэх;

1.16.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

1.17.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах журмыг батлах;

1.18.цар тахлын үед өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдол бүхий зарим бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээг авах;

1.19.улсын хилээр нэвтрэх болон дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт хийх;

1.20.гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түр хамгаалах байранд шаардлагатай хөрөнгө оруулалт болон 24 цагаар ажиллуулах утасны санхүүжилтийг шийдвэрлэх;

1.21.цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоох;

1.22.цар тахлын үед арга хэмжээ авахдаа хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

1.23.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, хэрэгслээр иргэдийг тэгш, хүртээмжтэй хангах;

		<p>1.24.Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч, холбогдох зардлыг шийдвэрлэх;</p> <p>1.25.үр тарианы болон хүнсний ногооны үрийн нөөц бүрдүүлэх, газар тариалангийн ургац тасалдахаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>1.26.экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн хяналт тавих.</p> <p>2/Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө.</p> <p>3/Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.</p>
3	<p>Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p><i>/8 дугаар зүйл/</i></p>	<p>1/Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>1.1.гадаад улсад байгаа Монгол Улсын иргэн буцаж ирэх хүсэлт гаргасан тохиолдолд тухайн улс дахь өвчлөлийн тархалт, эрсдэл, шууд нислэгийн боломж зэрэг бусад нөхцөл байдлыг харгалзан татан авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;</p> <p>1.2.Монгол Улсад байгаа гадаад улсын иргэн буцах хүсэлт гаргасан тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах;</p> <p>1.3.энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан ажиллагааны хүрээнд зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг баталж, хэрэгжүүлэх;</p> <p>1.4.дамжин өнгөрөх болон улс хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хүрээнд ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг батлах;</p> <p>1.5.хүнсний болон бусад нөөц бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах.</p>
4	<p>Төрийн бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p><i>/9 дүгээр зүйл/</i></p>	<p>1/Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>2/Хилийн боомтоор нэвтэрч байгаа зорчигч, тээврийн</p>

хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх, халдварын сэжигтэй зорчигчийг илрүүлэх, тандах, тусгаарлалтад шилжүүлэх зэрэг хилийн нэвтрэх цэгт авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний журмыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3/Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах зааврыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

4/Халдварт өвчнөөс хамгаалах зориулалттай эмнэлгийн хэрэгслийг эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг тодорхойлсон лабораторийн шинжилгээг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон нэг удаагийн импортын лицензээр тусгай зөвшөөрөл шаардалгүйгээр улсын хилээр оруулах ба уг хамгаалах хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5/Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цар тахлын халдварын эмчилгээнд шаардлагатай шинэ төрлийн эм, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг түргэвчилсэн журмаар бүртгэнэ.

6/Хүнсний болон бусад нөөц бүрдүүлэх зорилгоор бараа бүтээгдэхүүнийг импортлоход түүнчлэн дотооддоо үйлдвэрлэхэд шаардагдах түүхий эд, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

7/Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын хилээр оруулахгүй байж болно.

8/Зорчигч, тээврийн хэрэгслийг хорио цээрийн дэглэмийн үед улсын хилээр нэвтрүүлэхэд хилийн хяналтын байгууллагаас гадна холбогдох эрх бүхий байгууллагын төлөөлөл хилийн боомтод ажиллаж болох ба уг үйл ажиллагаанд мөрдөх тусгай журмыг хилийн боомтын зөвлөлийн дарга батлан мөрдүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

9/Хилийн боомтоор зорчигчийн улсын хил нэвтрэх үеийн баримт бичгийг хялбаршуулсан журмаар шалгах бөгөөд холбогдох журмыг улсын хил хамгаалах байгууллагын дарга батална.

10/Цар тахлын үед шүүгч, прокурорыг 24 цагаар ажиллуулах журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурор тус тус баталж,

		<p>хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>11/Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх болон бусад эрх бүхий байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зарим ажиллагааг цахимаар явуулж болох бөгөөд эдгээр байгууллага иргэний үндсэн эрх, эрх чөлөөний баталгааг дордуулахгүйгээр өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журмыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>12/Олон улсын шуудан солилцооны үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг хангаж, улсын хил, гаалиар түргэвчилсэн горимоор нэвтрүүлэх журмыг гаалийн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p> <p>13/Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p> <p>14/Хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосны улмаас Монгол Улсаас гарах боломжгүй болсон нь холбогдох баримтаар тогтоогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсын визийн болон тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацааг тухайн нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгах, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.</p>
5	<p>Төв банк болон арилжааны банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p><i>/10 дугаар зүйл/</i></p>	<p>1/Төв банк цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар зайлшгүй тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p> <p>1.1.төгрөгийн болон банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн тодорхой салбарыг дэмжих, банкны санхүүгийн байдлыг сайжруулах зорилгоор банканд зээл олгох Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан үйл ажиллагаа явуулж, хуульд заасан арга, хэрэгслийг ашиглах;</p> <p>1.2.гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор дотоод болон гадаадын улс, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хуулийн этгээдээс зээл болон бусад хэлцлээр гадаад валют авах, худалдан авах нөхцөлтэйгөөр дотоодын банк, санхүүгийн байгууллагад зээл олгох.</p> <p>2/Энэ хуулийн 10.1-д заасан зээл, хэлцлийн нөхцөл, шаардлагыг Төв банк тогтооно.</p> <p>3/Энэ хуулийн 10.1-д заасан арга хэмжээг авахад Төв</p>

	<p>банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4, 7 дахь заалт хамаарахгүй.</p> <p>4/Цар тахлын үед банкны харилцах дансанд хүү тооцохгүй, гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй бөгөөд иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.</p> <p>5/Эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргана.</p> <p>6/Барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Төв банкнаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлнэ.</p> <p>7/Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нийт 6 хүртэлх сараар хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ.</p>
--	--

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, арга хэмжээнд тавих шаардлага /11 дүгээр зүйл/

1/Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг нэг мөр хангана:

1.1.хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх;

1.2.үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх;

1.3.үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх;

1.4.хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх;

1.5.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх.

2/Энэ хуульд заасан арга хэмжээ нь тухайн нөхцөлд тохирсон тодорхой хамрах хүрээ, хугацаатай байх бөгөөд цугларсан мэдээллийг нийгмийн эрүүл мэндийг хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахыг хориглоно.

3/Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байна.

4/Энэ хуулийн 11.1-д заасан шийдвэр, арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлнэ.

5/Хүний эрхийн үндэсний комисс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд энэ хуульд заасан арга хэмжээнд хяналт тавина.

Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

№	Иргэн, хуулийн этгээд	Эрх, үүрэг
1	1/Иргэн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар дараах эрхтэй	<p>1.1.холбогдох байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах;</p> <p>1.2.цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй тохиолдолд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах;</p> <p>1.3.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар гаргасан шийдвэр, арга хэмжээ энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангаагүйгээс эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах;</p> <p>1.4.хуульд заасан бусад эрх.</p>
	2/Иргэн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар дараах үүрэгтэй	<p>2.1.эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалтын дэглэм, заавар, журам, шаардлага, сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмжийг сахин биелүүлэх;</p> <p>2.2.өөрийн эрүүл мэндийн байдал, аяллын түүх зэрэг халдвар судлалд шаардлагатай мэдээллийг үнэн зөв өгөх;</p> <p>2.3.мэргэжлийн байгууллагын шаардлагын дагуу үзлэг, шинжилгээнд заавал хамрагдах;</p> <p>2.4.цар тахлын халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өөрийгөө тусгаарлан эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэх;</p> <p>2.5.албан байгууллага, олон нийтийн газарт амны хаалт тогтмол зүүх, гараа тогтмол угаах, өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах;</p> <p>2.6.цар тахлын халдварын үед тусгаарлах, ажиглах журмыг чанд сахих;</p> <p>2.7.халдварын голомттой улсаас ирсэн, эсхүл халдварлагдсан байж болзошгүй бол эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцөл, хугацаанд тусгаарлалтын дэглэмд байх;</p> <p>2.8.татан авалт, тусгаарлалт, үйлчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх зэрэгтэй холбогдон гарах зайлшгүй зардлыг төлөх;</p>

		<p>2.9.эрх бүхий байгууллагын шийдвэрийг зөрчсөний улмаас гарсан зардлыг хариуцах;</p> <p>2.10.хуульд заасан бусад үүрэг.</p>
	<p>3/Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно.</p> <p>4/Иргэн халдварт өвчнийг бусдад зориуд халдаасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>	
2	<p>1/Аж ахуйн нэгж, байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар дараах эрхтэй</p>	<p>1.1.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах;</p> <p>1.2.цар тахлын эсрэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөгөө авах, хандив, тусламж өгөх;</p> <p>1.3.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар гаргасан шийдвэр, арга хэмжээ энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангаагүйгээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах;</p> <p>1.4.хуульд заасан бусад эрх.</p>
	<p>2/Аж ахуйн нэгж, байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар дараах үүрэгтэй</p>	<p>2.1.эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалтын дэглэм, заавар, журам, шаардлага, сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмжийг сахин биелүүлэх;</p> <p>2.2.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;</p> <p>2.3.ажлын байранд агааржуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх;</p> <p>2.4.иргэн болон ажилтныг халдвараас сэргийлэх нөхцөлийг эрх бүхий байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу бүрдүүлэх;</p> <p>2.5.хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тусгаарлалтын дэглэмд байгаа ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах;</p> <p>2.6.энэ хуулийн 7.1.1-д¹ заасан журамд хориглосон хэлбэрээр олон нийтийг биечлэн хамруулах арга хэмжээ, уулзалт зохион байгуулахгүй байх;</p> <p>2.7.үйл ажиллагаагаа мэдээллийн технологи ашиглан цахимаар явуулах боломжийг бүрдүүлэх;</p> <p>2.8.гамшгийн үед түрээсийн төлбөрийг нэмэх, бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй</p>

¹Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг батлах;

	байх; 2.9.цар тахлын үед өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, эмзэг болон эрсдэлт бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах; 2.10.хуульд заасан бусад үүрэг.
3/Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно.	
Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг	1/Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ. 2/Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ.

Хандив /15 дугаар зүйл/

1/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг Улсын онцгой комисс бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд ил тод байлгаж, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

2/Энэ хуулийн 15.1-д заасан хандивын тодорхой хэсгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.17-д² заасан санд төвлөрүүлж, цар тахалтай холбоотойгоор гадаадын улс орноос тогтоосон хөл хорио, хилийн хязгаарлалтын улмаас эх орондоо буцах боломжгүй болсон, санхүүгийн хүндрэлд орсон иргэдээс тодорхой шалгуурыг хангасан зорилтот бүлэгт тусламж үзүүлэхэд зарцуулж болно.

Эд хөрөнгийн дайчилгаа /16 дугаар зүйл/

1/Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг дайчлан авч болно.

2/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг дайчилсан тохиолдолд тухайн хөрөнгийн урсгал, эсхүл үйл ажиллагааны зардлын хэмжээгээр нөхөх олговор олгоно.

3/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг дайчлан гаргуулсан тохиолдолд нөхөх олговрыг тооцох, олгох журмыг Улсын онцгой комиссын санал болгосноор Засгийн газар батална.

² Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.17.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан;

4/Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага /17 дугаар зүйл/

1/Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2/Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу батлагдан гарах эрх зүйн баримт бичгийг *Хавсралт 1*, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг *Хавсралт 2*-оос тус тус үзнэ үү.

Хуулийг дэлгэрэнгүй байдлаар эх хувиар нь:

www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312 хандаж үзнэ үү.

ХУУЛИЙН ХЭЛТЭС

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу дагалдах гарах эрх зүйн акт, зөвшөөрлийн тухай

№	Журмын нэр	Батлах субъект
1	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, уг үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагыг татан оролцуулах журам	Улсын онцгой комиссын санал болгосноор Засгийн газар
2	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах журам	Засгийн газар
3	Зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журам	Улсын онцгой комисс
4	Ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журам	Улсын онцгой комисс
5	Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журам	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
6	Хилийн боомтоор нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх, халдварын сэжигтэй зорчигчийг илрүүлэх, тандах, тусгаарлалтад шилжүүлэх зэрэг хилийн нэвтрэх цэгт авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний журам	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
7	Нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах зааврыг	Эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран
8	Тусгай зөвшөөрөл шаардалгүйгээр улсын хилээр оруулах хамгаалах хэрэгслийн жагсаалт	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

9	Хилийн хяналтын байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагын төлөөлөл хилийн боомтод ажиллах үед үйл ажиллагаанд мөрдөх тусгай журам	Хилийн боомтын зөвлөлийн дарга
10	Хилийн боомтоор зорчигчийн улсын хил нэвтрэх үеийн баримт бичгийг хялбаршуулсан журмаар шалгах журам	Хил хамгаалах байгууллагын дарга
11	Цар тахлын үед шүүгч, прокурорыг 24 цагаар ажиллуулах журам	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурор хамтран
12	Олон улсын шуудан солилцооны үйлчилгээг улсын хил, гаалиар түргэвчилсэн горимоор нэвтрүүлэх журам	Гаалийн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран
13	Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх, цахим орчинд зохицуулалт хийх журам	Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран
14	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг дайчлан гаргуулсан тохиолдолд нөхөх олговрыг тооцох, олгох журам	Улсын онцгой комиссын санал болгосноор Засгийн газар

-----oOo-----

Эрүүгийн хууль

	Гэмт хэргийн шинж	Шийтгэл
15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах		
1	Бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчний үед эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хорио цээр, хязгаарлалтын дэглэм, холбогдох бусад журам, заавар, шаардлагыг зориуд санаатайгаар зөрчиж халдварт өвчин тархах нөхцөл бүрдүүлсэн, эсхүл бусдад халдаасан бол	хоёр мянга долоон зуун нэгжээсарван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , -эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах , -эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ .
18.1 дүгээр зүйл. Зах зээл дэх монополь, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах		
2	Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед үнийн хөөрөгдөл, бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдлыг бий болгосон бол	Таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ .

Зөрчлийн тухай хууль

	Зөрчлийн шинж	Шийтгэл
5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих		
1	Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	-хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, -хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	-хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, долоогоос гуч хүртэл хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, -хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3	Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүйгээр, саадгүйгээр мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол	хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4	Гамшгаас хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол	-хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,

		-хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5	Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор байгуулсан барилга байгууламжийг эвдэж гэмтээсэн, эсхүл зориулалтыг дур мэдэн өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	-учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, -хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, -хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6	Тусламж үзүүлэгч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол	-хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, -хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүл мэндийн тухай хууль

20 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

1	Эрүүл мэндийн байгууллага дараах эрх эдэлнэ:	<p>1/хүн амын эрүүл мэндтэй холбогдсон асуудлыг мэргэжлийн дээд шатны байгууллага буюу нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>2/аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга өгөх;</p> <p>3/мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих;</p> <p>4/байгууллагын зорилго, эрх, үүрэгт харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхээс татгалзах;</p> <p>5/иргэн болон байгууллагын буруутай үйлдлээс болсон осол гэмтэл, хордлого зэргээс үүдэн эрүүл мэндийн байгууллагаас гарсан гэнэтийн зардлыг Иргэний хуульд нийцүүлэн буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;</p> <p>6/халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх;</p> <p>7/хууль тогтоомжид заасан бусад эрх.</p>
---	--	--

-----oOo-----